Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2020 оны .... дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт

# НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

| Д/д | Шалгуур, үзүүлэлт | Мэдээлэл |
|---|---|---|
| 1. | **Ургийн овог**<br>**Эцгийн нэр**<br>**Өөрийн нэр** | Ноён цорс<br>Батзэвэг<br>Энхболд |
| 2. | **Хүсэлт гаргагчийн хаяг** | |
| 3. | **Төрсөн огноо** | |
| 4. | **Боловсрол**<br>Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ. | 2013-2016 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёонгги их сургуульд Хууль зүйн ухааны доктор (Ph.D), Дипломын №1704, 2016.02.19<br><br>2007-2009 онд Цагдаагийн академид Хууль зүйн магистр (LL.M), Дипломын №E20093296, 2009.03.31<br><br>2003-2007 онд Цагдаагийн академид Эрх зүйч- Цагдаагийн ажил мэргэжлээр бакалавр, Дипломын №D200721046, 2007.06.08 |
| 5. | **Ажил эрхлэлт**<br>Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ. | 2017-2020 онд Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч,<br>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, VIII хороо, Хилчний гудамж, ш/х-210332, холбоо барих утас: 70155037, 70155005, https://www.uia.gov.mn/<br><br>2016-2017 онд Монгол Улсын Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрхлэгч,<br>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, VIII хороо, Хилчний гудамж, ш/х-210332, холбоо барих утас: 70155034, 70155005, https://www.uia.gov.mn/<br><br>2008-2013 онд Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх, криминологийн тэнхимд багш, ахлах багш,<br>Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, VIII хороо, Хилчний гудамж, ш/х-210332, холбоо барих утас: 70155026, https://www.uia.gov.mn/ |

| | | |
|---|---|---|
| | | 2007-2008 онд Цагдаагийн академийн Цагдаагийн анхан шатны сургалтын төвд багш, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, VIII хороо, Хилчний гудамж, ш/х-210332, холбоо барих утас: 70155026, https://www.uia.gov.mn/ |
| **6.** | **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал** | Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүн |
| **7.** | **Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил**<br>Хүсэлт гаргагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. | 2017-2020 онд Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч,<br>Ажлын байрны тодорхойлолт<br>- Эрүүгийн эрх зүй, криминологи хичээлийн (бакалавр, магистр, доктор) сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, багш нарыг мэргэжил, заах арга зүйн удирдлагаар хангах, гүйцэтгэлийн болон чанарын хяналт тавьж үр дүнг тооцох;<br>- Тэнхимийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг мэргэжлийн удирдлагаар ханган үр дүнг сургалт, судалгаа, практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх;<br>- Өөрийгөө болон багш, албан хаагч, суралцагчийг хөгжүүлэх, чадавхжуулах ажлыг зохион байгуулах, тэдний ажлын хариуцлага, сахилга, ёс зүйн байдалд хяналт тавьж, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;<br>- Ажлын барын зорилгод нийцүүлж, бусад хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.<br><br>2016-2017 онд Монгол Улсын Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цагдаа судлалын төвийн эрхлэгч,<br>Ажлын байрны тодорхойлолт<br>- Цагдаа судлалын үндсэн болон тэргүүлэх чиглэлээр зорилтот судалгаа-боловсруулалтын ажил гүйцэтгэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хуулийн төсөл, бодлогын баримт бичиг зөвлөмж гаргах;<br>- Шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт арга, хэрэгслийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, шинэ мэдлэг бүтээх, сургалт, судалгааны эргэлтэд оруулах, үр ашигтай технологи дамжуулах, нутагшуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, гадаад, дотоодын сургалт судалгааны байгууллагатай холбогдох судалгааны чиглэлээр хамтран ажиллах;<br>- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгээр ном, бүтээл туурвих, шинжлэх ухааны сурталчилгаа хийх, эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцож, илтгэл хэлэлцүүлэх, судалгааны арга зүйг бүрэн эзэмших, мэдлэг боловсролоо байнга дээшлүүлэх.<br><br>2008-2013 онд Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх, криминологийн тэнхимд багш, ахлах багш |

| | | |
|---|---|---|
| | | Ажлын байрны тодорхойлолт<br>- Эрүүгийн эрх зүй, криминологийн хичээлийн сургалтыг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;<br>- Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, дэмжлэг үзүүлэх;<br>- Өөрийгөө хөгжүүлэх, суралцагчийг чадавхжуулах;<br>- Ажлын барын зорилгод нийцүүлж, хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.<br>Ажлын байрны тодорхойлолт<br>- Хүний эрх ба цагдаа, Цагдаагийн алба хаагчийн ёс зүй хичээлийг сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;<br>- Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, багш, суралцагчдад дэмжлэг үзүүлэх;<br>- Өөрийгөө хөгжүүлэх, суралцагчийг чадавхжуулах;<br>- Ажлын байрны зорилгод нийцүүлж, хариуцуулсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. |
| **8.** | **Ёс зүй** | - Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байгаагүй.<br>- Сүүлийн 5 жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй. |
| **9.** | **Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар**<br>Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.<br>-Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;<br>-Үйл ажиллагааны гол агуулга;<br>-Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;<br>-Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан тавaac доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;<br>-Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. | 1. Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Дотоодын цэргийн тухай хуулийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийн гишүүн, Хууль зүйн байнгын хорооны даргын 2017 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 06 дугаар тогтоол, дээрх хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар тус тус ажилласан.<br>Агуулга: Хуулийн төсөл боловсруулах,<br>Үр дүн: Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар батлагдсан. Төрийн мэдээлэл сэтгүүл, 2017 №8-д нийтлэгдсэн. Цагдаа, дотоодын цэргийн хуулийн харьцуулсан судалгаа хийж, 2017 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр зохион байгуулсан “Хууль төрөхийн өмнө” хэлэлцүүлэгт “Дотоод аюулгүй байдлыг хангах байгууллагын харьцуулсан судалгаа” сэдвээр мэдээлэл хийж ажилласан. Мөн ажлын хэсгийн ахлагчаас өгсөн үүрэг, даалгаврыг цаг тухайд нь биелүүлж, Дотоод хэргийн их сургуулийн цагдаагийн цол хэрэглэж буй алба хаагчдын эрх зүйн байдлыг тодорхой болгох чиглэлээр хэд хэдэн санал боловсруулж, Цагдаагийн албаны тухай хуульд тусгуулж ажилласан. |

| | | |
|---|---|---|
| | | 2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын дэд хэсгийн гишүүнээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн А/58 дугаар тушаалаар ажилласан.<br>Агуулга: Хуулийн төсөл боловсруулах.<br>Үр дүн: Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар баталсан. Төрийн мэдээлэл 2017. №-д нийтэлсэн. Ажлын хэсгийн хуралдаанд тогтмол оролцож, “Эрүүгийн хуулийн эмгэгийг эмчлэх нь” нийтлэл, Үндэсний шуудан сонины 2017 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн дугаарт, 2017 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр “Хууль төрөхийн өмнө” хэлэлцүүлэгт ажлын хэсгийн гишүүн С.Гантулгын хамт “Монгол Улсын ялын бодлогын өөрчлөлт” илтгэл хэлэлцүүлсэн.<br>3. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын дэд хэсгийн гишүүнээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/58 дугаар тушаалаар ажилласан.<br>Агуулга: Хуулийн төсөл боловсруулах:<br>Үр дүн: Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2017 оны 05 дугаар сарын 11 өдрийн хуралдаанаар баталсан. Төрийн мэдээлэл сэтгүүлд нийтлэгдсэн. Ажлын хэсгийн хуралдаанд тогтмол оролцож, зөрчилд оногдуулах шийтгэлийн хэмжээг 2015 онд баталсан Зөрчлийн тухай хуультай харьцуулан танилцуулга бэлтгэсэн.<br>4. Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангуулах байнгын ажлын хэсэгт Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн тушаалаар ажилласан.<br>Агуулга: Дээрх хуулиудыг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаатай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжруулах болон шаардлагатай тохиолдолд холбогдох бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх<br>Үр дүн: Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, УИХ-ын нэгдсэн чуулганаар батлуулсан.<br>5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлын дэд хэсгийн гишүүнээр УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор ажилласан.<br>Агуулга: Дээрх хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэгт мэргэжил, арга |

| | | |
|---|---|---|
| | | зүйн туслалцаа үзүүлэх.<br>Үр дүн: Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 6 дугаар сарын 6-ний өдрийн хуралдаанаар баталсан. Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2019 оны №42 дугаарт нийтлэгдсэн.<br>6. 2017-2018 онд “Эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгаж, шийдвэрлэхэд шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагчийн чадавхийг бэхжүүлэх нь” төслийн үндэсний зөвлөхөөр ажилласан.<br>Агуулга: Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход зөвлөх, сургагч багш бэлтгэх, гарын авлага боловсруулах.<br>Үр дүн: 2017 оны 3 дугаар сард “Эдийн засгийн гэмт хэргийн шинж, эрх зүйн зохицуулалт” сэдвээр Нийслэлийн дүүргүүдийн Ерөнхий шүүгч болон Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, прокурор, өмгөөлөгчидын төлөөлөл 30 хуульчдад 20 цагийн сургалт явуулж, “Эдийн засгийн гэмт хэрэг” сургагч багшийн гарын авлага боловсруулах ажлын хэсэгт зөвлөхөөр ажиллаж, 10 дугаар сард нийтийн хүртээл болсон. 2018 оны 3 дугаар сард “Эдийн засгийн гэмт хэргийн шинж, мөрдөх арга зүй” сэдвээр Улсын Ерөнхий Прокурор, Нийслэлийн болон дүүргийн прокурор, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мөрдөгч, нийт 40 албан хаагчид 20 цагийн сургалт явуулсан.<br>7. 2017-2018 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэглэх арга зүйн сургалтад сургагч багшаар ажилласан.<br>Агуулга: шинээр батлагдсан хуулийг нэг мөр ойлгох, хэрэглэх арга зүй, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх<br>Үр дүн: Улаанбаатар, Ховд, Завхан, Хөвсгөл, Булган, Орхон аймгийн хуульчдад сургалт зохион байгуулж ажилласан. Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын хуульчдын холбоо хамтран бэлтгэсэн “Эрүүгийн хууль”-ийн танилцуулгад оролцсон.<br>8. 2018 онд “Эрүүгийн эрх зүй: тусгай анги” 572 хуудас бүхий сурах бичгийг боловсруулсан.<br>Агуулга: Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчдын Эрүүгийн хуулийн нэр томьёо, ухагдахууныг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын агуулга, үзэл баримтлалыг сурталчлан таниулах, эрх зүйч мэргэжлээр суралцагчдад дэмжлэг үзүүлэх.<br>Үр дүн: Дотоод хэргийн их сургуулийн Эрүүгийн эрх зүйн хичээлийн үндсэн сурах |

| | | |
|---|---|---|
| | | бичиг, хууль зүйн их, дээд сургууль, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд эрэлт хэрэгцээтэй сурах бичиг болсон.<br>9. “Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дүрэм”, “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”, “Хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журам”-ын төсөл боловсруулах ажлын хэсэгт ажилласан.<br>Агуулга: Журмын төсөл боловсруулах<br>Үр дүн: Журам батлагдсан.<br>10. “БНСУ дахь цагаач Монголчууд ба уугуул Монголчуудын цагдаад итгэх хандлага: үзэл баримтлалын харьцуулсан судалгаа” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийг бичиж, International journal of law, crime and justice олон улсын импакт, фактор бүхий сэтгүүлд нийтлүүлсэн.<br>Агуулга: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг БНСУ болон Монгол улсын жишээн дээр харьцуулан судалж, зөвлөмж боловсруулсан.<br>Үр дүн: Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэнээр Монгол Улс криминологийн чиглэлээр Зүүн болон Зүүн Өмнөд Азийн орнуудаас өндөр хянан магадлагаа бүхий сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн 6 дахь улс, Монгол Улсын хууль зүйн салбарыг төлөөлөх анхны бүтээл болсноороо онцлог бөгөөд Монгол Улсын хуульч эрдэмтдийн нэр хүнд, ур чадварыг олон улсад сурталчлан таниулах, хүлээн зөвшөөрүүлэх үзүүлэлт болсон. https://montsame.mn/mn/read/59999<br>11. 2011-2013 онд иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зохих байгууллагад төлөөлөх, шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлж ажилласан.<br>Агуулга: шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлж ажилласан.<br>Үр дүн: Гэр бүлийн маргаан бүхий 4 удаагийн шүүх хуралдаанд оролцож, үйлчлүүлэгчийн эрх ашиг сонирхлыг хамгаалсан.<br>Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; |
| **10.** | **Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил**<br>Хүсэлт гаргагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он | - 2019-2020 онд “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ” бодлогын судалгааны багийн ахлагч<br>- 2019 оны 5 дугаар сард “Хүүхэд буруугүй” сэдэвт мэдлэг сорих тэмцээний зохион байгуулагч /Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах |

| | | |
|---|---|---|
| | дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-Ажлын байрны тодорхойлолт;<br>-Удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан тавааc доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. | зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран зохион байгуулсан/<br>- 2017-2019 онд “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Алба хаагчдыг чадавхжуулах нь” төслийн зохицуулагч.<br>- 2017-2018 онд “Цагдаагийн байгууллага: хэрэглэгчийн үнэлгээ- 2017” судалгааны төслийн удирдагч<br>- 2013-2016 онд БНСУ-ын Кёонгги их сургуулийн Цагдаагийн удирдлага, криминологийн тэнхимд судлаач, профессор |
| **11.** | **Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал**<br>Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-Үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;<br>-Үйл ажиллагааны гол агуулга;<br>-Үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;<br>-Үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-Хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан тавааc доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;<br>-Хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. | 1. 2019-2020 онд “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ” бодлогын судалгаа.<br>Агуулга: Хүүхдийн эсрэг хүчирхийллийн ноцтой хэлбэр болсон бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг нээн илрүүлж, ялын бодлого, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх ажлын зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх.<br>Үр дүн: Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, тайлан боловсруулж, холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлсэн.<br>Хамтран ажилласан байгууллага: Нээлттэй нийгэм форум<br>http://www.forum.mn/res_mat/2020/ChildVictims_Researchreport.pdf<br>2. 2019 оны 5 дугаар сард “Хүүхэд буруугүй” сэдэвт мэдлэг сорих тэмцээнийг санаачлан зохион байгуулсан.<br>Агуулга: Хүүхэд хүчирхийлэлд өртөж байгаа шалтгаан, нөхцлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хөндөгдсөн эрхийг сэргээх, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах мэдлэг, хандлага төлөвшүүлэх.<br>Үр дүн: Хууль зүйн их, дээд сургуулийн оюутан, суралцагчдад хүүхдэд ээлтэй мэргэжлийн үйл ажиллагаа явуулах хандлага төлөвшсөн.<br>Хамтран ажилласан байгууллага: Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар.<br>3. 2017-2019 онд “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Алба хаагчдыг чадавхжуулах нь” төслийн зохицуулагчаар ажилласан.<br>Агуулга: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, тэдэнтэй хүнлэг энэрэнгүй, ёс зүйтэй харьцах хамтран ажиллах хандлага төлөвшүүлэх. |

| | | |
|---|---|---|
| | | Үр дүн: “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сургагч багшийн болон суралцагчийн гарын авлага боловсруулсан, үндэсний хэмжээнд 34 сургагч багшийг бэлтгэсэн. Төв, орон нутгийн шүүх, прокурор, цагдаа, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын албаны 900 гаруй албан хаагч, Дотоод хэргийн их сургуулийн 2000 гаруй сонсогчдод нийт 24 удаагийн сургалт зохион байгуулсан. АНУ-ын Төрийн Департаментын ХХГХ-ийн талаарх 2018 оны тайланд Монгол Улс анхаарах ёстой орны (Tier 2 - Watch List) жагсаалтад багтаж байсан бол 2019 онд хохирогчийг илрүүлэх, эх оронд нь эргүүлэн авчрах, энэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтэд ахиц гаргасан улс гэж үзэж анхаарал татсан улсын жагсаалтаас гаргасан.<br>Хамтран ажилласан байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн сан, Улсын Ерөнхий Прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар<br>http://www.arslan.mn/social/sergiilegch/608763.shtml<br><br>4. 2019 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Гүнт зусланд байрлах "Rodem house" асрамжийн төвийн 20 хүүхдэд бүтээлийн борлуулалтын орлогоос хандив, тусламж үзүүлж, мөн оны 6 дугаар сард мэргэжлийн чиг баримжаа олоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор тэдэнд Дотоод хэргийн их сургуулийг танилцуулж, сургалт явуулсан.<br>Агуулга: Хүүхдэд ээлтэй үйл ажиллагааг олон нийтэд таниулах, хүүхдийн хамгааллын үйл ажиллагаанд оролцох<br>Хамтран ажилласан байгууллага: Дотоод хэргийн их сургууль, Цагдаагийн сургуулийн “Гэмт явдал судлал” суралцагчдын клуб<br><br>5. 2017-2018 онд “Цагдаагийн байгууллага: Хэрэглэгчийн үнэлгээ-2017” судалгааны төсөл.<br>Агуулга: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, хүртээмжтэй болгох, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх.<br>Үр дүн: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэдийн оролцоонд тулгуурлан үнэлэх аргачлал боловсруулсан, 2018 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр судалгааны үр дүнгийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст албан хэрэгцээнд судалгааны тайланг зөвлөмжийн хамт хүргүүлсэн.<br>Хамтран ажилласан байгууллага: Цагдаагийн ерөнхий газар, Нээлттэй нийгэм форум, Хөдөө аж ахуйн их сургуулийн Статистик эдийн засгийн тэнхим. https://www.facebook.com/OpenSocietyForum/posts/1755138981278518/ |

| | | |
|---|---|---|
| | | 6. 2013-2016 онд БНСУ-ын Кёонгги их сургуулийн Цагдаагийн удирдлага, криминологийн тэнхимд судлаач, профессороор ажиллаж “Монголчуудын цагдаад итгэх хандлага: харьцуулсан судалгаа” суурь судалгаа явуулж, докторын зэрэг хамгаалсан.<br>Үр дүн: Иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байх хүчин зүйлсэд хүний эрхийг хязгаарлах эрх мэдлээ урвуулан ашигладаг, үйл ажиллагаандаа хууль ёсны болон шударга ёсны зарчмыг мөрдлөг болгож ажилладаггүй байдал ихээхэн нөлөөтэй болохыг судалгаагаар тогтоож, зөвлөмж боловсруулсан.<br>Хамтран ажилласан байгууллага: Дотоод хэргийн их сургууль, БНСУ-ын Кёонгги их сургуулийн Цагдаагийн удирдлага, криминологийн тэнхим, БНСУ-ын Цагдаа судлалын холбоо<br><br>7. Өмгөөлүүлэх эрхээр хангах зарчмын мөн чанар, хууль зүйн учир холбогдол, судалгааны тайлан боловсруулсан.<br>Агуулга: Эрүүгийн хэрэг үүсгэх шатанд сэжигтний өмгөөлүүлэх эрхийг хангах ажлыг боловсронгуй болгох.<br>Үр дүн: Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 2012, №3,4 дугаарт нийтлэгдсэн.<br><br>8. Хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмын хэрэгжилтийг эрх зүйн зохицуулалтаар үгүйсгэж буй байдал,<br>Агуулга: Хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмын нэг мөр хэрэгжүүлэх.<br>Үр дүн: Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 2011 оны №4 дугаарт нийтлэгдсэн.<br><br>9. “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь өмгөөлүүлэх эрхийг харьцуулан судалсан нь” судалгааны тайлан.<br>Агуулга: Өмгөөлүүлэх эрхийг хангаж буй олон улсын туршлагыг судлах<br>Үр дүн: Өмгөөлөгч сэтгүүлийн 2008 №6 дугаарт нийтлэгдсэн.<br><br>10. Албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх албадлагын бусад арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал,<br>Агуулга: Төрийн өндөр албан тушаалтны хуулиар олгогдсон бүрэн эрхийг түдгэлзүүлэх практик, жишгийг судлах.<br>Үр дүн: Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 2008 №3 дугаарт нийтлэгдсэн. |

| | | |
|---|---|---|
| | | 11. Монгол Улсад гарсан хэлмэгдүүлэлтийг өмгөөлүүлэх эрхийг хангах зарчмын үүднээс авч үзэх нь, судалгааны тайлан<br>Агуулга: Хэлмэгдүүлэлт хүний эрхийн ноцтой зөрчил болж буй байдлыг өмгөөлүүлэх эрхийн жишээн дээр тайлбарласан.<br>Үр дүн: Өмгөөлөгч сэтгүүлийн 2008 №11 дугаарт нийтлэгдсэн.<br><br>12. "Эрүүгийн хэрэг үүсгэх шатанд дахь өмгөөлүүлэх эрхийг хангах зарчмын хэрэгжилт, өнөөгийн байдал"<br>Агуулга: Эрүүгийн хэрэг үүсгэх шатанд сэжигтний өмгөөлүүлэх эрхийг хангах ажлыг боловсронгуй болгох.<br>Үр дүн: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.14 дүгээр зүйлд тусгалаа олсон. Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 2012 №3,4 дугаарт нийтлэгдсэн. |
| **12.** | **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар**<br>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл<br>Жич: Энэ зүйл нь Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй. | |
| **13.** | **Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар**<br>Монголын Хуульчдын холбоо, Монголын | - БНСУ-ын Цагдаа судлалын холбооны гишүүн, (2019.01.01)<br>- Монголын криминологчидын холбооны гишүүн, (2015 оноос хойш)<br>- Монголын хуульчдын холбооны гишүүн. Хуульчдаас сонгон шалгаруулах ажлыг |

| | | |
|---|---|---|
| | Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ. | эрхлэн гүйцэтгэх орон тооны бус зөвлөлийн даргын 2011 оны 9 дүгээр 12 өдрийн шийдвэрээр хуульчийн гэрчилгээ авч байсан. 2013 онд БНСУ-д суралцаж байх хугацаанд хүчингүй болсон. |
| **14.** | **Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл**<br>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.<br><br>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.<br>-Лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.<br><br>-Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө. | Нэг. Сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл<br>1. Хууль зүйн шинжлэх ухааны судалгааны арга зүй. гарын авлага. УБ, 2018, (Хамтын бүтээл)<br>2. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. сурах бичиг. УБ, 2018. (Хамтын бүтээл)<br>3. Цагдаагийн байгууллага: Хэрэглэгчийн үнэлгээ-2017”. гарын авлага, УБ, 2018<br>4. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2017, гарын авлага. УБ., 2018 (Хамтын бүтээл)<br>5. Монголд Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016”. гарын авлага. УБ., 2017. (Хамтын бүтээл)<br>6. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Албан хаагчдыг чадавхжуулах нь”, УБ., 2018. сургагч багшийн болон суралцагчийн гарын авлага, (Хамтын бүтээл)<br>7. Захиргааны журмын эсрэг гэмт”, сургалтын гарын авлага. УБ., 2013. (Хамтын бүтээл)<br>8. Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг”. сургалтын гарын авлага. УБ., 2012. (Хамтын бүтээл)<br>9. Хотжилт ба гэмт явдал”. нэг сэдэвт бүтээл. УБ., 2011<br>10. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тусгай ангийн сорилын хураамж”. УБ., 2011. сургалтын гарын авлага, (Хамтын бүтээл)<br><br>Хоёр. Эрдэм шинжилгээний өгүүлэл<br>Монгол хэлээр<br>1. “Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил: онол, дүн шинжилгээ”, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл, 2020 №1<br>2. Нуугдмал гэмт явдлыг хэмжих арга зүй”, Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл 2019 №2<br>3. “Цагдаагийн албан хаагчийн дундаж наслалт, түүнд хийсэн судалгаа” Гэмт |

| | | |
|---|---|---|
| | **Жич:** Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана. | явдалтай тэмцэх асуудал сэтгүүл, 2018 №3<br>4. “Цагдаад итгэх олон нийтийн хандлага: онол, судалгаа” Цагдаа сэтгүүл, 2017, №1<br>5. Монгол Улсын ялын бодлогын өөрчлөлт, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл 2017.№1<br>6. Дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага: Монгол Улс ба гадаадын зарим орны жишээн дээр, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл 2017 №1<br>7. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй онол, практик, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл, 2016. №3<br>8. Хот төлөвлөлт ба гэмт явдал, Гэмт явдалтай тэмцэх асуудал 2012, №1<br>9. Зам тээврийн үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, зүйлчлэлийн асуудал, Цагдаа судлал сэтгүүл 2011№1<br>10. Улаанбаатар хот дахь шунахайн гэмт явдлын онцлог, урьдчилан сэргийлэх зарим асуудал, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл 2010 №3<br>11. Монгол Улсын эрүүгийн хууль дахь нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, зүйлчлэлийн зарим асуудал” Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл 2010 №2<br>12. Үйлдвэрлэл, шинжилгээ, судалгааны ажлын үндэслэл бүхий эрсдлийн онол, практикийн асуудал, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл, 2009 №4<br>13. Гэмт хэрэг үйлдэгдэхэд хууль бус зар сурталчилгааны нөлөөлөл, анхаарах асуудал, Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл 2009 №3<br>14. Гэмт явдалд хотжих үйл явцын нөлөөлөл, урьдчилан сэргийлэх арга зүй, Монголын төр, эрх зүй сэтгүүл 2010 №3,<br><br>Гадаад хэлээр<br>1. Confidence in the Police among Mongolian Immigrants in Korean and Native Mongolians in the home country: A Comparative Test of Conceptual” “International journal of law, Crime and Justice” 2017 №2-т нийтлүүлсэн<br>2. Trust In the Police In A Transitional Society: Mongolian Case Journal of Korean criminology 2015.№3<br>3. Criminal justice system in Mongolia, Korean Terrorism studies review 2015.№4<br>4. Crime Trend and Emerging Crime Types after Democratization in Modern Mongolia: The Effect of Social Transition and Urbanization” Terrorism studies review 2014.№4<br>5. The Effect of Modernization Developments on Criminal Victimization throughout Nations: A Multilevel Approach” Korean Terrorism studies review 2013.№4<br><br>Гурав. Хэлэлцүүлсэн илтгэл |

1. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан: Сургалт, эрдэм шинжилгээний ажил, Дотоод хэргийн их сургуулийн түүхэн замнал, хөгжлийн хандлага, Олон улсын эрдэм шинжилгээний хурал, УБ., 2019
2. Terrorist financing and money laundering, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал, Олон улсын эрдэм шинжилгээний хурал, УБ., 2018
3. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа: Хил хамгаалах байгууллагын алба хаагчдыг чадавхжуулах нь, Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, Олон улсын эрдэм шинжилгээний хурал, УБ., 2018
4. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй байдал: онол, практик", ХБНГУ, 2016
5. "Цагдаад итгэх хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийн судалдгаа", Даяаршил ба цагдаа сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, БНСУ 2013,
6. Факторы урбанизаций, влияющие на преступность", /Том хотуудын аюулгүй байдлыг хангах арга зам сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, ОХУ, 2012

Дөрөв. Хянан тохиолдуулсан бүтээл

1. Хүүхэд хөгжлийн орчин үеийн асуудлууд" Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2018
2. Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хууль тогтоомжийн эмхэтгэл, УБ. 2017
3. Х.Оюунбаатар. "Логик" дасгалын ном, УБ., 2017
4. Хууль сахиулах ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, Уб, 2016
5. Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүлийн 15 дугаарыг эрхлэн гаргасан.

Тав. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэл

1. БНСУ-ын оршин суугаа иргэдийн эрх зүйн мэдлэгт, ярилцлага, Дэлхийн Монгол MGL.88.3 Радио, 2020.04.29 https://soundcloud.com/mglradio/mm-podcast-zochin-benkhbold-2?fbclid=IwAR3HjVa5cwYkN03XZ5ukMhbz-jgPdbtIQ0r1QLHaT0GpGOCnncmIiinfozA
2. Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг явуулах эрх зүйн орчин бүрдсэн, ярилцлага. ДХИС-ийн подкаст, 2020.04.17 https://www.facebook.com/UniversityofInternalAffairs/videos/847663395738056/
3. Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө, ярилцлага, Eagle HD телевиз, "Сэргийлэлт" нэвтрүүлэг, 2020.02.13
4. Хүчирхийллийн үндэсийг ураг төрлөөс хайя, ярилцлага, Зууны мэдээ сонин,

| | | |
|---|---|---|
| | | 2020.02.06 №25, https://www.uia.gov.mn/news-details/81<br>5. ЦЕГ-аас бэлтгэдэг “Амрыг эрье” нэвтрүүлэгт “Хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх асуудал”, ярилцлага, МҮОНТ, 2020.01.20<br>6. Хар тамхитай тэмцэх сургалтын орчин бүрдсэн, ярилцлага, TV9 телевиз, 2019.02.22<br>7. Эрүүгийн хууль тогтоомжид шинэчлэл хийснээр хэрэгжилт сайжирна, Эрдмийн далай сонин, 2019.03.25<br>8. Цагдаагийн албан хаагч, улс төрийн үйл ажиллагаанаас ангид байх зохицуулалт тусгагдсан, ярилцлага, Улс төрийн тойм сонин, 2017.04.07 №063<br>9. Эрүүгийн хуулийн эмгэгийг эмчлэх нь, Үндэсний шуудан сонин, 2017.01.12 №008, https://mojha.gov.mn/newmojha/?p=1197<br>10. Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын хуульчдын холбоо хамтран бэлтгэсэн “Эрүүгийн хууль”-ийн танилцуулага. https://www.facebook.com/mojgovmn/videos/796663417177600/?v=796663417177600<br>11. Хууль сахиулах байгууллагууд нэгдсэн бодлогод зангидагдаж чаддаг болсон, ярилцлага, http://www.assa.mn/a/39665<br>12. “Монголчуудын цагдаад итгэх хандлагын харьцуулсан судалгаа: инструментал болон экспрессив загварчлалаар шалгах нь” сэдэвт лекц http://nli.gov.mn/?p=4678<br>13. Дотоодын аюулгүй байдлыг хангах байгууллага дэлхийн 80 гаруй улсад бий илтгэл- ярилцлага http://itoim.mn/article |

--- oOo ---